



**МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМ**

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160
Утас: 33 07 81. Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddc.gov.mn
Цахим хуудас: www.mddc.gov.mn

2022.12.30 № 03/2373
танай _____-ны № _____-т

**ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Х.БАТЖАРГАЛ ТАНАА**

“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”, “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны яамны эрхлэх асуудлын хүрээнд боловсруулан үүгээр хүргүүлж байна.

Хавсралт..6. хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Ч.ЗОЛБАЯР



1522097418

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
12 дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралт

**“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТЭМДЭГЛЭЛ**

(2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар)

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Улсын Их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 2022 оны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй харьцуулан хэрэгжилтийн түвшинг тогтоон үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв бодитой мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг 7.1-т заасны дагуу зорилт арга хэмжээг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлэв.

Гурав. Хяналт-шинжилгээний үр дүн

“Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн баримт бичигт туссан зорилт, арга хэмжээг үнэлэхдээ зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй харьцуулан, хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйг ашиглан үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримтлав.

Онцлон дурдахад тус яамны хувьд Улсын Их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан төсөл арга хэмжээ байхгүй тул бодлогын баримт бичгийн 1 дүгээр хавсралтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Гурван зорилтын хүрээнд тусгагдсан зургаан арга хэмжээнээс эрчимжүүлэх шаардлагатай нэг арга хэмжээ туссан байна. Өөрөөр хэлбэл Бодлогын баримт бичгийн 7.5-д “Кибер аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, технологид суурилсан инновац, интеграцийг хөгжүүлж, эрсдэлийн менежментийн үндэсний чадавхыг бэхжүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд туссан “Мэдээлэл, технологи, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн тогтолцоо бүрдэж, технологийн хараат байдал буурч, кибер гэмт хэрэг, кибер халдлагатай тэмцэх чадавх дээшилсэн байна” гэх арга хэмжээний хувьд биелэлтийг тайлагнахдаа “Төрийн болон онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төвийг Тагнуулын байгууллагын бүтцэд, хувийн хэвшлийн болон

иргэдийн кибер аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх нийтийн төвийг цахим хөгжил, харилцаа холбооны яамны дэргэд байгуулахаар Кибер аюулгүй байдлын тухай хуулиар зохицуулсан. Улмаар Тагнуулын байгууллагатай хамтран Цахим халдлага, зөрчилтэй тэмцэх төв байгуулах ТЭЗҮ боловсруулж, 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулсан. 2023 оны төсөвт кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төв байгуулах, үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой хөрөнгө тусгагдаагүй тул удаашралтай байна. Кибер аюулгүй байдлын хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хуульд заасан журмын төсөл, аргачлалуудыг боловсруулж, Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна” гэжээ.

Мөн Хяналт-шинжилгээ хийх явцад яамны нэгжүүдийн ирүүлсэн биелэлтэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ болон нотлох баримтыг оновчтой оруулаагүй, нотлох баримтаар оруулсан файлаа нэрлээгүй, 2000 тэмдэгтэд багтаан тайлагнаагүй, зорилт, арга хэмжээ нь хүрсэн түвшинтэйгээ нийцэхгүй, тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжит хугацаа олгоогүй гэх зэрэг зөрчлүүд илэрлээ.

Дөрөв. Дүгнэлт

1.2022 оны жилийн эцсийн байдлаар бодлогын баримт бичигт туссан гурван зорилт зургаан арга хэмжээг нягтлан үзэж, цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд ерөнхий гүйцэтгэл 85 хувьтай гэж дүгнэгдэв.

2.“Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн бодлогын баримт бичигт Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн ерөнхий үнэлгээгээр “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үзэж байна.

Тав. Санал, зөвлөмж

1.Бодлогын баримт бичгийн нийт зорилт арга хэмжээг 2021-2025 оны хооронд хийхээр төлөвлөсөн зорилтууд тодорхой байгаа боловч, зарим арга хэмжээний хүрэх түвшинг он оноор нь нарийвчлан тусгаж өгөөгүйгээс тухайн жилд ямар ажил хийж гүйцэтгэсэн байхаар тогтоосон нь төдийлөн тодорхойгүй байлаа. Иймд цаашид бодлогын баримт бичгүүд болон бусад төлөвлөлт шаардлагатай бичгүүдэд арга хэмжээний зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг нарийн ойлгомжтой хэмжигдэхүйц байхаар тусгаж хэвших;

2.Биелэлтийг гаргахдаа Засгийн газрын 2020 оны 206, 374 дүгээр тогтоолд заасны дагуу хугацааг анхаарч нотлох баримттай, үр дүнд суурилсан байдлаар тайлагнаж хэвших шаардлагатай. Заасан хугацааг анхаарч ажиллаагүй албан хаагчид арга хэмжээ авах саналтай байна;

3.Төсвөөс шалтгаалах ажлын төлөвлөгөөг гаргахдаа бодит, дүн шинжилгээтэй, баримтад тулгуурласан хэрэгжихүйц байдлаар төлөвлөж байх;

4.Баримт бичигт туссан төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргахдаа харьяа байгууллагуудын нэмэлт мэдээллийг авч тусгаж хэвших.

Жич: Яамны газар, хэлтсийн дарга нар дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, нэгжийн албан хаагчдадаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй болохыг дурдах нь зүйтэй байна



"Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн
2022 оны жилийн эцсийн хэрэгжилт

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2021 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
4. ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ							
1	4.2. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	4.2.5. Мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	0		1. "Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар хийж гүйцэтгүүлэх боломжтой чиг үүрэг, ажил үйлчилгээний жагсаалт"-ыг боловсруулж, ЗГХЭГ-т 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 01/1808 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2. Төрийн программ хангамжийн худалдан авах ажиллагааг шинэ түвшинд гаргах, үргүй зардлыг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Үндэсний программ хангамжийн их дэлгүүр www.MINDGOLIA.mn системийг 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр нээж, тус платформд 100 гаруй компанийн 180 орчим бүтээгдэхүүн байршсан ба нээлт хийхээс өмнөх туршилтын үеэр/ 30 хоногт 5 төрлийн 4,5 тэрбум төгрөгийн системийг 21 аймгийн 248 Ерөнхий боловсролын сургууль төлбөрийг нь төлөх нөхцөлтэйгөөр хэрэглэж, худалдан авсан. 3. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 196 дугаар тогтоолоор баталсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ын дагуу Үндсэн систем "ХУР"-тай холбогдох 26 байгууллагын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.	100%
5. ТАВ. ЗАСАГЛАЛ							
2		5.3.1. Цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, хүн амыг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбоно.	2021 - 2025	0		1. "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль", "Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль", "Кибер аюулгүй байдлын тухай хууль", "Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хууль"-ийн төслүүд 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр УИХ -ын чуулганаар хэлэлцэгдэж батлагдсан. Дээрх 4 хуулийг дагаж 37 захиргааны хэм хэмжээний акт батлагдахаас 2022 оны 12 дугаар сарын байдлаар 20-ны өдрийн байдлаар нийт 19-ийг нь батлуулж, 14 төсөлд санал авч байна. 2. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар нэг аймгийн нэг багт 60км урт шилэн кабель, 3500 амжиргааны түвшин доогуур өрхөд суурин интернэт үйлчилгээгээ хүргэх зорилгоор 154 км урт шилэн кабель тус тус суурилуулж өндөр хурдны өргөн зурвасын суурин интернет сүлжээг байгуулсан. Мөн алслагдсан 238 багт үүрэн холбооны 4G сүлжээ нэвтрүүлсэн ба нийт 300 мянга орчим иргэн өндөр хурдны хөдөлгөөнт интернэтэд холбогдох, мэдээ, мэдээлэл шуурхай авах, аялагч амрагчид харилцаа холбооны бусад үйлчилгээг саадгүй, шуурхай авах боломжийг бүрдүүлсэн. Хавсралт : 1 файл	80%

3		5.3.2. Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болгож хөгжүүлэх нэгдсэн бодлого, төлөвлөлттэй болгоно.	2021 - 2025	13400	<p>1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоол "Нээлттэй өгөгдлийн жагсаалт", 200 дугаар тогтоол "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"-ын хүрээнд нийт 59 байгууллагын 606 нээлттэй өгөгдлийг opendata.gov.mn-д байрлуулахаар төлөвлөснөөс 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 56 байгууллагын 518 нээлттэй өгөгдлийг байршуулаад байна.</p> <p>2. Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2022 оны А/79, А/193 тушаалаар Статистикийн үйл ажиллагаанд хамаарах нийтийн мэдээллийн сангийн нэгдсэн ангилал кодын тайлбарыг баталсан.</p> <p>3. Төрийн их өгөгдлийн сан байгуулах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох зорилгоор үндэсний өгөгдлийн талаар баримтлах чиглэл боловсруулах, нийтийн мэдээллийн сангийн мета өгөгдлийн системийг үүсгэх шийдэл боловсруулах ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2022 оны 12 дүгээр сарын 07-ны өдрийн А/84, А/209 тушаалаар байгуулж, ажиллах удирдамжийг баталсан. Тус ажлын хэсэг нь Монгол Улс дахь их өгөгдлийн суурь нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, олон улсад хэрэгжүүлж буй дэвшилтэд технологийг нэвтрүүлэх, өгөгдлийн нийцтэй байдал, өгөгдлийн урсгалын зургийг гаргах зэрэг ажлыг эхлүүлээд байна.</p> <p>Хавсралт : 2 файл</p>	80%
4	5.3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлнэ.	5.3.3. Төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоо сайжирч, захиргааны зардал бууран, үйлчилгээний үр дүн сайжирна.	2021 - 2025	0	<p>1. "Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал"-ыг ЦХХХ-ны Сайдын 2022 оны А/64 дүгээр тушаалаар батлагдсан.</p> <p>2. Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем (eрe-mongolia.mn) -д 1'384 төрийн байгууллага, түүний салбар нэгжийг холбож, нийт 20'390 хэрэглэгч тус системээр дамжуулан байгууллага хооронд 167'707 албан бичгийг цахим хэлбэрээр солилцсон байна.</p> <p>3. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 45 дугаар тэмдэглэлээр Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтөд цахим хэлбэрээр баримт бичиг солилцох нөхцөл бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах асуудлыг судалж, зохих арга хэмжээ авах саналаа танилцуулахыг даалгасны дагуу "Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтөд цахим хэлбэрээр баримт бичиг солилцох нөхцөл бүрдүүлсэн тухай" арга хэмжээний танилцуулга 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн Засгийн гарын хуралдаанд танилцуулагдсан. Албан бичиг солилцооны дундын системд 2022 оны 12 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 4302 байгууллагын ашиглалдаг 15 систем холбогдсон бөгөөд нийт 8116 бичиг солилцсон байна.</p> <p>Хавсралт : 1 файл</p>	80%

5		5.3.4. Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдал нэмэгдэж, иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлнэ.	2021 - 2025	0	<p>1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг 2021 оны 12 дугаар сарын 17 -ны өдрийн УИХ -ын чуулганы хуралдаанаар хэлэлцэн баталсан.</p> <p>2. Иргэдэд төрийн байгууллагаас олгодог баримт бичиг, гэрчилгээ, зөвшөөрөлтэй холбоотой төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдлийг "Мэдэгдэл хүргэх систем"-ээр дамжуулан авах боломжийг бүрдүүлж, иргэдэд 2022 оны 05 дугаар сараас 12 дугаар сарын 20 хүртэл нийт 13,464,420 мэдэгдлийг Push Notification , Үндэсний и-мэйл , Хувийн и-мэйлээр хүргэсэн байна.</p> <p>3. Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгож, нээлттэй, ил тод, шуурхай байлгах зорилгоор төр, иргэнийг холбосон мэдээлэл дамжуулах цахим суваг болох "ҮНДЭСНИЙ ЦАХИМ ШУУДАН"-ийн систем /www.mail.e-mongolia.mn/-ийг нэвтрүүлж, 1,6 сая хэрэглэгчид мэдэгдэл хүргэх боломжийг бүрдүүлсэн. Үндэсний цахим шуудангийн системд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага (193 хаяг)-ын албаны цахим шууданг холбож, өргөдөл, гомдлыг хүлээн авч, хариу хүргүүлэх боломжийг бүрдүүлсэн.</p> <p>4.Төрийн үйлчилгээний нэгдсэн e-mongolia системд "Авилгалтай тэмцэх газарт өргөдөл гомдол гаргах" цэсийг шинээр нэмж, хөгжүүлсэн.</p> <p>5. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын хүрээнд иргэний мэдээлэл хайх, мэдээлэл хүлээн авах эрхийг хангах зорилгоор мэдээлэл хариуцагч төрийн байгууллагуудын байнга ил тод байх нь зүйтэй гэж 68 төрлийн мэдээллийг ил тод, нээлттэй байлгах аар зохицуулсан. Засгийн газрын хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагуудаас санамсаргүй байдлаар 18 байгууллагыг сонгон авч хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж, цахим хуудсандаа мэдээллийг ил тод байршуулж байгаа явцад үнэлгээ хийсэн. Дунджаар 43,34% үнэлгээтэй байна.</p> <p>6. Цахим оролцоо веб сайтыг хөгжүүлэн иргэд нийгэмд тулгамдаж буй асуудлаар асуулга үүсгэх, уг саналыг дэмжих, дэмжихгүй байх саналыг цахим хэлбэрээр өгөх боломж бүрдүүлсэн.</p> <p>Хавсралт : 1 файл</p>	100%
7. ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ						
6	7.5. Кибер аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, технологид суурилсан инновац, интеграцыг хөгжүүлж, эрсдэлийн менежментийн үндэсний чадавхыг бэхжүүлнэ.	7.5.2. Мэдээлэл, технологи, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн тогтолцоо бүрдэж, технологийн хараат байдал буурч, кибер гэмт хэрэг, кибер халдлагатай тэмцэх чадавх дээшилсэн байна.	2021 - 2025	0	<p>Тагнуулын байгууллагатай хамтран Цахим халдлага, зөрчилтэй тэмцэх төв байгуулах ТЭЗҮ боловсруулж, 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулсан. 2023 оны төсөвт кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төв байгуулах, үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой хөрөнгө тусгагдаагүй тул удаашралтай байна. Кибер аюулгүй байдлын хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хуульд заасан журмын төсөл, аргачлалуудыг боловсруулж, Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.</p> <p>Хавсралт : 1 файл</p>	70%



МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМ

Сүхбаатарын талбай 1 Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот. 15160
Утас: 33 07 81 Факс: (976-11) 33 07 80.
Цахим шуудан: info@mddc.gov.mn
Цахим хуудас: www.mddc.gov.mn

2022.12.30 № 03/2373
танай _____ -ны № _____ -т

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Х.БАТЖАРГАЛ ТАНАА

"Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө", "Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны яамны эрхлэх асуудлын хүрээнд боловсруулан үүгээр хүргүүлж байна.

Хавсралт..... хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА  Х.ЗОЛБАЯР



152097417



Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны
12 дугаар сарын 03/2022 дугаар албан бичгийн хавсралт.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө Цахим хөгжил, харилцаа холбооны яам 2022 оны жилийн эцэс

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
4. Засаглалын бодлого							
1		4.1.1. Төрийн цахим үйлчилгээний e-mongolia платформын ашиглалтыг нэмэгдүүлэх, иргэдэд танин мэдүүлэх арга хэмжээг зохион байгуулах, төрийн үйлчилгээний төрөл, тоог нэмэгдүүлж хөгжүүлэх, иргэдэд хүргэх арга хэмжээг зохион байгуулах	Төрийн цахим үйлчилгээний e-mongolia платформын ашиглалтыг нэмэгдүүлэх, иргэдэд танин мэдүүлэх арга хэмжээг зохион байгуулах, төрийн үйлчилгээний төрөл, тоог нэмэгдүүлж хөгжүүлэх, иргэдэд хүргэх арга хэмжээг зохион байгуулах	Тус системээр үйлчилгээ авч байгаа иргэдийн тоог 200000-аар нэмэгдүүлсэн байна. Төрийн болон хувийн хэвшлийн 20 байгууллагын үйлчилгээг нэгдсэн холбосон байна.	0	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем И-Монголиад 71 байгууллагын 806, орон нутгийн 1285 үйлчилгээг нэгтгэсэн. Мөн 10 тодорхойлолтыг англи хэл дээр гаргадаг болсон. 2022 онд 383,750 хэрэглэгч шинээр бүртгэгдсэн. Төрийн үйлчилгээний нэгдсэн системийг олон нийтэд танин мэдүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийсэн. Үүнд: -18 аймагт албан томилолтоор ажиллан орон нутгийн үйлчилгээг системд нэгтгэх, операторуудыг сургах болон нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулсан; -21 аймаг, 330 сум, 9 дүүргийн нийт 13952 албан хаагчид; -Орон нутгийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд зүүн болон төвийн бүсийн 13 аймгийн иргэдэд заавар зөвлөлгөө өгөх ажлыг зохион байгуулсан; -2022 оны 04 дүгээр сарын 23, 24-ий өдрүүдэд Нарантуул ОУХТ-д нээлттэй хаалганы өдөрлөгийг УБЕГ-тай хамтран зохион байгуулсан; -2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр мэдэгдэл хүргэх системийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулсан; -АТТ-тэй хамтран Авто машингүй өдөр нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, иргэдэд мэдээ, мэдээлэл судалгаа хийсэн ба 2 удаагын сургалтыг зохион байгуулсан; -Чингэлтэй дүүргийн УБ-ийн хэлтсээс зохион байгуулсан Иргэн бүрийг тоон гарын үсэгжүүлэх "Цахимаар шийдье" арга хэмжээнд 2022 оны 05 дугаар сарын 30-нд оролцсон; -3 удаагын нээлттэй хаалганы өдөрлөг, 11 арга хэмжээнд оролцон, 56 хороодод очин өдөрлөг зохион байгуулсан.	100%
2		4.1.2. Хиймэл оюун ухаанд суурилсан технологи иргэдэд төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх платформыг хөгжүүлж нэвтрүүлэх	Хиймэл оюун ухаанд суурилсан технологи ашиглан иргэдэд төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх платформыг хөгжүүлж нэвтрүүлэх	Иргэдэд төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх платформ шинээр бий болсон байна. Нэн шаардлагатай төрийн үйлчилгээний 5 системийг мэдэгдэл хүргэх нэгдсэн системд холбосон байна.	0	1.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны 30 дугаар тэмдэглэлээр Үндэсний цахим шуудангийн хэрэглээг нэвтрүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах талаар хугацаатай үүрэг даалгавар Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн. 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдөр "Үндэсний цахим шуудангийн үйлчилгээ"-г нэвтрүүлсэн бөгөөд нийт 193 цахим шуудангийн хаягийг нэгтгэсэн. Ингэснээр иргэд төрийн байгууллагатай цахим шуудангаар шууд харилцах боломжтой. 2. Төрийн байгууллагаас иргэдэд мэдэгдэл, мэдээлэл хүргэх зорилготой "Мэдэгдэл хүргэх систем"-ээр дамжуулан нийт 12.363.002 мэдэгдлийг иргэдэд хүргэсэн. Мэдэгдэл хүргэх системд 16 байгууллага (И-Монголиа академи УТУГ, Татварын ерөнхий газар, Гэрээ системс ХХК, Төрийн банк, Голомт банк, Богд банк, Капитрон банк, Хасбанк, Тэвээр хөгжлийн банк, E-Mongolia, Худалдаа хөгжлийн банк, Хаан банк, ОБЕГ, ХХҮЕГ, ГӨҮ SMART ТМ ХХК, Ариг банк)-ын системийг холбосон бөгөөд мессэжээр 1,545,783, үндэсний цахим шуудангаар 86,986 мэдэгдэл иргэнд хүргүүээд байна. Мөн Төрийн үйлчилгээний нэгдсэн и-Монголиа системд серверийн өргөтгөл, программ хангамжийн сайжруулалт хийн, Төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглаж байгаа бүх хэрэглэгчид богино хугацаанд нэгэн зэрэг мэдэгдэл илгээх боломж бүрдэж 23 мэдээлэл хариуцагчийн 298 төрлийн үйлчилгээний талаарх 1,504,225 мэдэгдлийг иргэнд хүргүүлсэн байна. 3. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарах лавлагаа, тодорхойлолтыг файл (pdf) хэлбэрээр авах боломжийг бүрдүүлэх зорилгоор lavлага.e-mongolia.mn системийг хөгжүүлсэн. Мөн "Үндсэн систем (ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний 8.2 дахь заалтыг үндэслэн "Үндсэн систем ашиглан үйлчилгээ үзүүлэх нэмэлт гэрээ"-ний төслийг боловсруулсан. Хавсралт : 3 файл	100%

3	4.1.6. Тоон бичиг үсэгтэн болгох сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулж, түгээх	Тоон бичиг үсэгтэн болгох сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулж, түгээх	Монгол Улсын хэмжээнд мэдээлэл, харилцаа, холбооны технологи ашиглах иргэдийн чадварын түвшин 50 хувьд хүрсэн байна.	0	1.Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/24 дугаар тушаалаар батлагдсан "Цахим Үндэстэн" дунд хугацааны хөтөлбөрт Тоон бичиг үсэгтэн болох зорилгыг дэвшүүлж цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэлийг тодорхойлсон. "Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх" төлөвлөгөөг БШУЯ, ЦХХХЯ, ХНХЯ, СоЯ-ны сайдын нарын 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/260/А/39/А/146/А/260 дугаар хамтарсан тушаалаар батлуулж, хэрэгжилтийг хангуулахаар холбогдох яамд болон И-Монгол академид хүргүүлсэн. Дээрх сайдын хамтарсан тушаалын хэрэгжилттэй холбогдуулан И-Монгол академи нь орон нутгийн ЗДТГ, ТББ болон олон улсын байгууллагуудтай хамтран 2022 онд нийт 10430 иргэн, 11056 төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх ажлын хүрээнд 2022 он 09 дүгээр сарын 01-30 хооронд "Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэд болон ахмад настай иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт"-ын төлөвлөгөөг тус яамны ТНБД-ын 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/69 дугаар тушаалаар батлуулан "И-Монгол академи" УТУГ-ын Цахим ур чадвар хөгжүүлэлтийн албаны сургагч багш нартай хамтран Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх 14 цагийн сургалтад 35 иргэнийг, ахмад настай иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 105 иргэнийг хамруулан зохион байгуулав. Мөн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/310 дугаар тушаалаар "Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадамжийн бүтцийн хүрээг тодорхойлох, сургалтын хөтөлбөр боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадамжийн бүтцийн хүрээг тодорхойлж, суурь судалгаа авч, 3 түвшний сургалтын хөтөлбөр боловсруулахаар ажиллаж байна.	100%
4	4.1.8. Иргэдэд тоон гарын үсэг олгож, цахим харилцаанд оролцох боломжийг бүрдүүлэх	Иргэдэд тоон гарын үсэг олгож, цахим харилцаанд оролцох боломжийг бүрдүүлэх	Шинээр 22.0 мянган иргэнд тоон гарын үсэг олгосон байна.	0	Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Улсын бүртгэлийн байгууллагаас иргэнд тоон гарын үсэг олгох талаарх зохицуулалтыг тусгасан. Хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлсэн тэй холбоотойгоор Төрийн албан хаагчид гэрчилгээ олгох, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулах журмыг сайдын 2022 оны А/28, Нийтийн түлхүүрийг гэрчилгээжүүлэх, гэрчилгээ олгосон, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тухай мэдээллийг агуулсан гэрчилгээний үндэсний санг бүрдүүлэх журмыг сайдын 2022 оны А/30 дугаар тушаалаар тус тус баталж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Улсын бүртгэлийн байгууллагаас 21 аймаг, 330 сум, 9 дүүрэг, 171 хорооны бүртгэлийн нэгжээр дамжуулан нийт 415,858 иргэнд олгосон бөгөөд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас нийт 88,586 хуулийн этгээдэд тоон гарын үсгийн гэрчилгээ олгоод байна. Иргэн, хуулийн этгээд тоон гарын үсэг ашиглан танилт, нэвтрэлтийн систем ашигладаг төрийн 89 байгууллага, хувийн хэвшлийн 111 байгууллагын системээр дамжуулан цахим хэлбэрээр үйлчилгээ авах боломжтой болсон.	100%
5	4.1. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.	4.1.9. Үндэсний хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах сургалтын бий болгох	Үндэсний хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах сургалтын бий болгох	0	Япон Улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Техникийн хамтын ажиллагааны төслөөр их дээд сургуулиуд, Удирдлагын академ, И-Монгол академ УТУГ-ын мэдээллийн аюулгүй байдлын сургагч багш нарыг чадавжуулахаар тохиролцож, 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдөр кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд гарын үсэг зурж баталгаажуулсан. Сургагч багш бэлтгэх сургалтыг 2023 оны эхлүүлэхээр төлөвлөсөн бэлтгэл ажлын хүрээнд Шинжлэх ухаан технологийнх сургуульд түшиглэн сургагч багш бэлтгэх сургалтын лабораторийг байгуулахаар ажиллаж байна. Боловсрол, шинжлэх ухааны сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Соёлын сайдын 2022 оны А/260, А/391, А/146, А/260 дугаар хамтарсан тушаалаар "Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2022-2026)"-г баталсан. Уг төлөвлөгөөнд "Ахисан түвшний сургалт"-ын хөтөлбөрт кибер аюулгүй байдлын талаар багц сургалтын хөтөлбөр бэлтгэхээр тусгасан.	70%
6	4.1.11. Төрийн байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг цахимжуулж, албан хэрэг хөтөлөлт, албан бичиг солилцоог цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, албан бичиг солилцооны цахим системийг хөгжүүлэх	Төрийн байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг цахимжуулж, албан хэрэг хөтөлөлт, албан бичиг солилцоог цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, албан бичиг солилцооны цахим системийг хөгжүүлэх	Албан хэрэг хөтөлөлт, албан бичиг солилцоог цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, албан бичиг солилцооны цахим системийг хөгжүүлсэн байна.	0	1. Албан бичиг солилцооны дундын систем нь дэмжих системийн нэг төрөл бөгөөд хүн, хуулийн этгээд нь үндсэн болон дэмжих системийг ашиглан үйлчилгээ үзүүлэхэд тавигдах техникийн ерөнхий шаардлага ("Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал батлах тухай")-ыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/64 дүгээр тушаалаар батлуулсан. 2. Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем (ep.e-mongolia.mn) -ийг хөгжүүлэн төрийн 2085 байгууллагын салбар нэгжийг холбож, нийт 32,426 албан хаагчийн мэдээлэл бүртгэгдсэн. Системээр дамжуулан байгууллага хооронд 553,032 (Ирсэн бичиг+Явсан бичиг) албан бичгийг цахим хэлбэрээр солилцсон байна. 3. Албан бичиг солилцооны дундын систем (DocX)-ийг Аблессофт, ep.e-mongolia.mn, ЗГХЭГ-ийн системд холбосон бөгөөд Төрийн болон хувийн хэвшлийн нийт 15+ ep системийг албан бичиг солилцооны дундын системд холбон, 5483 байгууллага бүртгэж, одоогийн байдлаар 7987 албан бичгийн 8742 хавсралт файлыг солилцсон байна. Түүнчлэн Тоон гарын үсгийн Safenet, epass2003 төхөөрөмжийг дэмждэг болсон. Одоогоор Monpass, newcompass, Iridum ХХК-ийн тоон гарын үсгийн төхөөрөмж дээр туршилтыг хийж байна.	100%

7	4.1.12. Сум, суурин газрыг шилэн кабелийн сүлжээнд холбох /Дорнод аймгийн Дашбалбар, Чулуунхороот, Төв аймгийн Мөнгөнморьт, Баян-Өнжүүл, Дундговь аймгийн Баянжаргалан, Хөвсгөл аймгийн Ханх/	Сум, суурин газрыг шилэн кабелийн сүлжээнд холбох /Дорнод аймгийн Дашбалбар, Чулуунхороот, Төв аймгийн Мөнгөнморьт, Баян-Өнжүүл, Дундговь аймгийн Баянжаргалан, Хөвсгөл аймгийн Ханх/	Шилэн кабельд холбогдоогүй 6 суманд шилэн кабелийн сүлжээ татаж, өндөр хурдны интернэтийн үйлчилгээ авах дэд бүтцийг бий болгосноор бүх 330 сум, суурин холбосон байна.	0	Тайлант хугацаанд 6 сумыг шинээр шилэн кабелийн сүлжээнд холбож, дахин 6 сумыг шинээр шилэн кабелийн сүлжээнд холбох ажил хийгдэж эхлээд байна. 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтээр Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Гурван-Баян Улаан, Дэлгэрхаан сумын Хэрлэн-Баян Улаан, Булган аймгийн Хангал сум, Хялганат тосгоныг, Архангай аймгийн Хашаат сумыг тус тус шилэн кабелийн сүлжээнд холбосон. 2021-2022 онд "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ний хөрөнгө оруулалтаар Говь Алтай аймгийн Алтай сум, Дорнод аймгийн Халх гол сумыг шилэн кабелийн сүлжээнд холбосон. 2022 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх "Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл" -ийн хүрээнд Дорнод аймгийн Дашбалбар сум, Чулуунхороот сум, Төв аймгийн Мөнгөнморьт, Баян-Өнжүүл, Дундговь аймгийн Баянжаргалан, Хөвсгөл аймгийн Ханх зэрэг 6 сумыг шилэн кабелийн сүлжээнд холбох ажлын хийгдэх ба Бүгд Найрамдах Хятад Ард Улсын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж дууссаны дараа шилэн кабелийн суурилуулалт эхэлнэ. Энэхүү ажил хийгдэж дууссанаар Монгол улсын 330 сум бүгд шилэн кабелийн сүлжээнд холбогдож дуусна. БНҮҮС 2022 оны хөрөнгө оруулалтаар Өвөрхангай аймгийн Уянга сумын Жаргалант багт 60км урт шилэн кабелийн сүлжээ байгуулсан. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ний хөрөнгө оруулалтаар Дорнод аймгийн Халхгол сумын Ялалт багаас Халхгол сумруу 60км шилэн кабель сүлжээ байгуулсан.	70%
8	4.1.13. Хүн ам олноор суурьшсан, аялал жуулчлалын бүс нутгуудыг шилэн кабелийн сүлжээнд холбох	Хүн ам олноор суурьшсан, аялал жуулчлалын бүс нутгуудыг шилэн кабелийн сүлжээнд холбох	Шилэн кабельд холбогдоогүй 23 багт шилэн кабелийн сүлжээг татаж, өндөр хурдны интернэтийн үйлчилгээ авах дэд бүтцийг бий болгосон байна.	0	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар нэг аймгийн нэг багт 60км урт шилэн кабель, 3500 амжиргааны түвшин доогуур өрхөд суурин интернэт үйлчилгээг хүргэх зорилгоор 154 км урт шилэн кабель тус тус суурилуулж өндөр хурдны өргөн зурвасын суурин интернэт сүлжээг байгуулсан. Мөн алслагдсан 275 багт үүрэн холбооны 4G сүлжээ нэвтрүүлсэн ба нийт 300 мянга орчим иргэн өндөр хурдны хөдөлгөөнт интернэтэд холбогдох, мэдээ, мэдээлэл шуурхай авах, аялагч амрагчид харилцаа холбооны бусад үйлчилгээг саадгүй, шуурхай авах боломжийг бүрдүүлсэн.	80%
9	4.1.14. Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системийн туршилт хийж 5G сүлжээний туршилтын бүс үүсгэх	Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системийн туршилт хийж 5G сүлжээний туршилтын бүс үүсгэх	Монгол Улсад 2023 оноос хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системийг нэвтрүүлж эхэлсэн байна. Улаанбаатар хотод хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн туршилтын орчныг үүсгэсэн байна.	0	Монгол Улсад хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн (5G) системийг 2023 онд нэвтрүүлэхтэй холбогдуулан уг технологийн онцлог болох өндөр хурдны хөдөлгөөнт холбоо, машин хоорондын холбоо, юмсын интернетийн үйлчилгээний талаарх судалгаа хийж, эдгээрийг турших туршилтын үйл ажиллагааг аж ахуйн нэгжүүд үе шаттай хэрэгжүүлсэн. 1. Анхны туршилтыг 2021 онд "Digital Nation" арга хэмжээний үеэр амжилттай зохион байгуулсан ба туршилтад Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Зэт Ти И" компанийн хөгжүүлсэн харилцаа холбоо, дэд бүтэц, автоматжуулалт, IoT-д тулгуурласан 8 бүтээгдэхүүнийг, үүрэн холбооны Мобиком корпораци ХХК, Юнител ХХК-иуд 5G технологид тулгуурласан IoT бүтээгдэхүүн, мөн "Анд Глобал" ХХК автоматжуулалт болон интернэтийн үйлчилгээний "Ондо" брэнд бүтээгдэхүүнээ тус тус олон нийтэд танилцуулсан. 2. 2022 онд Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг, Хан-Уул дүүрэг, Чингэлтэй дүүрэгт Мобиком корпораци ХХК, Юнител ХХК, Ай Эн Мобайл ХХК, Скайтел ХХК хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн (5G) системийн туршилтын бүсийг тус тус үүсгэж, туршилтын амжилттай хэрэгжүүлж 2023 онд 5G технологийг Монгол Улсад нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангасан. Радио давтамжийн дунд хугацааны төлөвлөлтийг шинэчлэх ажил Дэлхийн радио холбооны их хуралтай уягдаж 2023 онд хийгдэхээр төлөвлөгдсөн.	100%
10	4.1.15. Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг байгуулах	Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг байгуулах	Улаанбаатар хотын Хонхорын станцыг тоон технологид шилжүүлсэн байна.	0	Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ний А/76 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсгийн хүрээнд Тоон радиогийн ТЗЗҮ-г шинэчлэн боловсруулсан. Мөн 2023 оны улсын төсвийн төсөөлөлд тусгуулахаар санал хүргүүлсэн.	50%
11	4.1.16. Худаг сувагчлалын багтаамжийг оновчтой ашиглах үүднээс том оврын физик болон ашиглахгүй байгаа шилэн кабелийг /хуучны/ сувагчлалаас чөлөөлж, шинээр их багтаамжийн шилэн кабелийг суурилуулах	Худаг сувагчлалын багтаамжийг оновчтой ашиглах үүднээс том оврын физик болон ашиглахгүй байгаа шилэн кабелийг /хуучны/ сувагчлалаас чөлөөлж, шинээр их багтаамжийн шилэн кабелийг суурилуулах	617 км физик кабелийг чөлөөлж, 75.2 км шилэн кабель татсан байна.	0	"Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ний хөрөнгөөр Улаанбаатар хотын төв зам дагуу Наран станцаас зүүн тийш Офицеруудын ордон чиглэлд, КШ-32 оор Бага тойруугаас их тойруу чиглэлд, КШ-68 аар, КШ-45 чиглэлд нийт 5000 м кабель чөлөөлсөн.	50%
12	4.1.17. Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох	Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох	Шуудангийн үндсэн сүлжээнд өрсөлдөөний орчин бүрдсэн байна.	0	1 Шуудангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д заасны дагуу "Шуудангийн үндсэн сүлжээ ашиглах эрх олгох, хяналт тавих журам"-ын төслийг боловсруулах, шуудангийн үндсэн сүлжээний өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийх ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/30 дугаар тушаалаар байгуулж, ажиллах удирдамжийг баталсан. Ажлын хэсгийн хурлыг 4 удаа зохион байгуулж, улс хоорондын болон дотоодын шуудан, ачаа тээврийн өнөөгийн нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл солилцож, журмын төслийг боловсруулах үндэслэлийг танилцуулсан. Мөн Монгол Улсын 21 аймаг, 30 сумдын Засаг даргын Тамгын газраас шуудангийн үйлчилгээний талаарх судалгааг авч нэгтгэсэн ба шуудангийн үндсэн сүлжээний эзэмшигчийн орлого, зарлагын шинжилгээг хийж, олон улсын туршлагаас судалсны дүнд журмын төслийг эхний байдлаар боловсруулан, ажлын хэсгийн гишүүдээс санал авсан.	50%

13	4.1. Цахим хөгжлийн нэгдсэн төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.	4.1.18. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах	Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах	Шинэ санаа, дэвшилтэт технологид суурилсан бизнесийг хөгжүүлж, холбогдох суурь судалгааг хийж, энтрепренёр болон гарааны бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх талаар иж бүрэн төлөвлөгөөг боловсруулсан байна.	0	1.Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн А/303 дугаар тушаалаар байгуулагдсан "Технологи дамжуулах төв болон хамтын оффист бүртгүүлсэн гарааны компани болон програм хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг төрөөс татварын бодлогоор дэмжих тухай" журам боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж журмын төсөл боловсруулсан. Журмын төслийг БШУЯ-наас 2022 оны 12 дугаар сард багтаан Засгийн газраар батлуулах тогтоолын төслийн жагсаалтад оруулсан. 2.Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарын шилдэг программ хангамж үйлдвэрлэгч болон стартап компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг Төв азийн бус нутгийн улсууд болох Узбекистан, Казакстан, Киргиз, Туркменистан, Тажикстан зэрэг орнуудад сурталчлах, мэдээллийн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортыг нэмэгдүүлэх, стартап компаниудыг бизнесээ тогтвортой эрхэлж, өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах тухай 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/738 дугаар албан бичгийг аяллын төлөвлөгөө болон 7 компанийн танилцуулгын хамт Гадаад харилцааны яаманд хүргүүлж хамтран ажилласан. 3 ХХМТ-ийн салбарын инновацын эко системийг бүрдүүлэх, мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх чиглэлээр төлөвлөгөөний төсөл боловсруулсан.	90%
----	--	---	---	--	---	--	-----